

ДУНДГОВЬ АЙМГИЙН ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Дундговь аймгийн Ууган сургуулийн нэг Дэлгэрцогт сумын дунд сургууль нь 1924 онд буюу олноо өргөгдсөн 13-р онд Дэлгэрцогт уулын хошуу танхимын дэргэд "Гишгүүрийн ус" –ны баруун хойд сэргэлэн дэнж дээр хоёр эсгий цагаан гэр барьж гал голомтоо бадраасан түүхтэй. Танхим анх 1 багш 16 сурагч 2 галчтай байгуулагдсан. Анхны багшаар Цэнд занги, галчаар Жамсран, Даваа нар ажиллаж байв. 1947 онд 7 жилийн бүрэн бус дунд сургууль болон өргөжсөн юм. 2003-2020 онуудад 9 жилийн сургууль нэршилтэй байснаа 2020 оноос хойш ерөнхий боловсролын сургууль болсон.

Үе үеийн захирлууд: 1924-1925 онд Цэнд занги, 1925-1937 онуудад Ц.Балдандорж, 1937-1946 онуудад Ө.Лхамхүү, 1946-1950 онуудад Ш.Сэмдум, 1950-1951 ондуудад Г.Бадамгарав, 1951-1952 онуудад Цэрэндорж, 1952-1954 онуудад Ц.Чунт, 1954-1955 онуудад Д.Лувсанбаяр, 1955-1957 онуудад Н.Шатар, 1957-1963 онуудад М.Төмөрсүх, 1963-1965 онуудад Б.Халтар, 1965-1978 онуудад Г.Цэгмид, 1978-1983 онуудад П.Тулга, 1983-1987 онуудад Б.Батмөнх, 1987-1990 онуудад Ж.Тогооч, 1990-1992 онуудад Б.Лхагва, 1992-1996 онуудад Ю.Дашдаваа, 1996-1999 онуудад П.Цогт, 1999-2008 онуудад С.Хонгорзул, 2008-2009 онуудад Базарсүрэн 2009-2012 онуудад М.Баярсүх, 2012-2013 онуудад Б.Иш- Ёндон, 2013-2018 онуудад М.Баярсүх, 2018-2020 онуудад М.Сэрсэндэмид, 2020 оноос хойш А.Мөнхбаатар одоог хүртэл тасралтгүй ажиллаж байна.



2023 оны байдлаар 9 бүлэг өдрөөр суралцаж буй 157 суралцагч, дүйцсэн хөтөлбөрөөр 11 суралцагч ерөнхий боловсролын сургуульд боловсрол олгох үйл ажиллагааг 32 багш, ажилтны бүрэлдэхүүнтэйгээр явуулж байна. Манай хамт олон нь 2017 онд сумын тэргүүний хамт олон, 2019 онд сумын тэргүүний хамт олон зэргээр амжилт гарган ажиллаж байна.

Сургалтын менежер Ж.Пүрэвсүрэн, нийгмийн ажилтан Э.Цэрэнханд, бага ангийн заах аргын нэгдлийн ахлагч Ч.Даариймаа, Дунд ангийн заах аргын нэгдлийн ахлагч А.Мядагмаа, бага ангийн багшаар монгол улсын зөвлөх багш Б.Даваажав, У.Уугантуяа, Г.Бадмаадагий, Н.Цээсүрэн, монгол хэл уран зохиолын багш Ө.Пүрэвсүрэн, математикийн багш Н.Цэвэгсүрэн, түүх, нийгмийн багш Ц.Билэг-Ариун, хими биологийн багш Д.Цэрэнханд, англи хэлний багш Г.Гэрэлмаа, физик, мэдээлэл зүйн багш Т.Буянхишиг, биеийн тамирийн багш А.Цэрэндэжид, Технологийн багш Ю.Дашдаваа, насан туршийн боловсролын багш Н.Батцэцэг, нярав Н.Мөнхцэцэг, Б.Сарнайцэцэг, номын санч Б.Эрдэнэцэцэг, дотуур байрны багш Н.Цэрэндолгор, үдийн цайны тогооч О.Байгальмаа, дотуур байрны тогооч Т.Болормаа, үйлчлэгч П.Болормаа, Д.Цэрэндаваа, Д.Оюунцэцэг, Сантехникч Ю.Раднаа, жижүүр Н.Батбаяр, дотуур байрны жижүүр О.Цогзолсүрэн, М.Алимцэцэг, Ё.Ишмаа нар ажиллаж байна.